



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

13119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2018.02.22 № 06/06

-ны № \_\_\_\_\_ -Т

7

ХЭНТИЙ АЙМГИЙН СТАНДАРТ,  
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Ч.ПҮРЭВДОРЖ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2017 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Үүрэг, хариуцлага

160031

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Хэнтий аймаг дахь Төрийн  
аудитын газар

ХЭНТИЙ АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛЗҮЙН  
ХЭЛТСИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Менежментийн захидал

### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Төсвийн зарцуулалтын талаар.....	2
Асуудал 2	
Нягтлан бодох бүртгэлийн талаар....	3
Асуудал 3	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар .....	4

2018 оны 02 дугаар 13 сар

## Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга, нягтлан бодогч нарт талархал илэрхийлье.

## АГ-ын ажиглалт

1. Халаалтын зардлаас 950,0 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс, 320,0 мянган төгрөгийн засварын материал авч батлагдсан төсөвт зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь:

1/Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-т нийцэхгүй байна.

2/Үнэн зөв байдал:

Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн т айланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Сангийн яамнаас баталсан орон тоог нэгээр хэтрүүлсэн нь:

1/Төсвийн тухай хуулийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, **орон тооны хязгаарт багтаан** төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтад нийцэхгүй байна

## Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

## АГ-ын зөвлөмж

1. Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллан батлагдсан төсвийн зарлагыг эдийн засгийн ангилалын дагуу бүртгэж байх
2. Батлагдсан орон тоог барьж ажиллах

## Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагчид танилцуулахад хүлээн зөвшөөрсөн албан тоот ирүүлсэн болно.

### АГ-ын ажиглалт

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан дараах мэдээллүүдийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Үүнд:

6.1.5-д заасан төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг байршуулаагүй,

6.4.8-д заасан Өр үүсгэсэн шийдвэрийн талаарх - 8.3 сая төгрөгийн 1 мэдээлэл, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр 7.1 сая төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй байна.

### Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

### АГ-ын зөвлөмж

3. Шилэн дансны тухай хуулийн 4-р зүйлд заасан зарчмыг баримтлан ажиллаж, 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх. Дээрх мэдээллийг 2018 оны 3 дугаар сарын 01-ний дотор нөхөн байршуулах

### Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагчид танилцуулахад хүлээн зөвшөөрсөн албан тоот ирүүлсэн болно.

### МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

#### ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР


#### БЭЛТГЭСЭН:

Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Х.ЕРКЕГҮЛ

Огноо: 2018.02.13



### АГ-ын ажиглалт

1. Өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгагдаагүй 491,1 мянган төгрөгийн томилолтын зардлыг тайлант онд хүлээн зөвшөөрч бүртгэсэн, 1465,8 мянган төгрөгийн томилолтыг өглөгийг санхүүгийн тайланд бүртгээгүй орхигдуулсан, түрээсийн зардалд 209,0 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлагаар тусгаагүй, зардалд хаасан зэрэг алдаа зөрчил байна. Энэ нь:

1/ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, 14.4.3.бүх өр төлбөр” гэсэн заалтад нийцэхгүй байна.

2/ Оршин байх: Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/, өр төлбөр тухайн байгууллагад бодитой оршин байх” гэсэн санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Эрсдэлүүд

1. Санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгээгүй байх
2. Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

### АГ-ын зөвлөмж

1. НББ-ийн тухай хуулийн 14.3.-д зааснаар анхан шатны баримтыг үндэслэн бүртгэл хөтөлж, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”

### Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагчид танилцуулахад хүлээн зөвшөөрсөн албан тоот ирүүлсэн болно.

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**ХЭНТИЙ АЙМГИЙН СТАНДАРТ,  
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН 2017  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор:  
Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112  
Цахим хаяг: [Khentii@audit.gov.mn](mailto:Khentii@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 70562147  
Цахим хаяг:

Аудитор: Х.Еркегүл  
Утас: 70562147  
Цахим хаяг: [erkegulkh@audit.gov.mn](mailto:erkegulkh@audit.gov.mn)

ТАБ-ын хаяг  
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн сум  
3-р баг АЗДТГ-ын байр  
Цахим хуудас: [Khentii@audit.gov.mn](mailto:Khentii@audit.gov.mn)

**2018 оны 02 дугаар сар**

## **Аудитын тайлан**

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан



1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:.....	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:.....	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:.....	3
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:.....	4
5. Дотоод хяналт:.....	5
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:.....	5
7. Шилэн дансны мэдээлэл:.....	
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:.....	5
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:.....	5
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:.....	5
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:.....	6
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:.....	6
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:.....	6
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	6
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:.....	7
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:.....	7

### Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн СХЗХ-ийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/82/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймгийн СХЗХ-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймгийн СХЗХ-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Х.Еркегүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий аймгийн СХЗХ-ийн төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 25-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 31 -нээс 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

### Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

### Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

СХЗХ нь "Орон нутгийн хөгжлийн стратеги чиг хандлагад нийцүүлэн аймаг орон нийгмийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүйн, баталгаажуулалт, сорьцын

хяналтын бодлогоо дэмжихэд оршино.” гэсэн эрхэм зорилгын дор Стандарт, хэмжил зүйн газрын эрхлэх асуудлын хүрээнд хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Хэнтий аймгийн СХЗХ-ийн дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг СХЗГ-аас олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймгийн СХЗХ-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 11 хяналтын горим, нарийвчилсан сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

**Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа

гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

### Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Хэнтий аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 149.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас урсгал зардалд 138,8 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсөв 10.5 сая төгрөгөөр дутуу ирсэн байна. Энэ нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлын санхүүжилт дутуу хийгдсэнтэй холбоотой байна.

### Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан дараах мэдээллүүдийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Үүнд:

1. 6.1.5-д заасан төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг байршуулаагүй,
2. 6.4.8-д заасан Өр үүсгэсэн шийдвэрийн талаарх - 8.3 сая төгрөгийн мэдээлэл, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр 7.1 сая төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй байна.

### Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 11 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Сангийн яамнаас баталсан орон тоог хэтрүүлсэн, өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй мөртлөө 491,1 мянган төгрөгийн томилолтын зардлыг тайлант онд зардлаар бүртгэсэн, тайлант оны 1465,8 мянган төгрөгийн томилолтын өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан, түрээсийн зардалд 209,0 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлагаар бүртгээгүй, зардалд хаасан нь нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримыг үндэслэн хөтлөөгүй, халаалтын зардлаас 950,0 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс, 320,0 мянган төгрөгийн засварын материал авч батлагдсан төсөвт зардлыг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцэхгүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, оршин байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. ЛАБ-СТА-В-3/

### **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй мөртлөө 491,1 мянган төгрөгийн томилолтын зардлыг тайлант онд зардлаар бүртгэсэн.
2. Тайлант онд 6603,2 мянган төгрөгийн томилолтын зардал гарсан боловч 5129,9 мянган төгрөгийг шилжүүлсэн ба үлдэгдэл 1465,8 мянган төгрөгийн томилолтын өглөгийн санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй орхигдуулсан
3. Түрээсийн зардалд 209,0 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлагаар тусгаагүй, зардалд хаасан зэрэг алдаа, зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн: Зөрүүтэй илэрхийлсэн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд залруулга хийж, НББ-ийн тухай хуулийн 14.3.-д зааснаар анхан шатны баримтыг үндэслэн бүртгэл хөтөлж, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” зөвлөмж хүргүүлэв.

### **Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Материаллаг бус 1.2 сая төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл байхгүй байгаа тул залруулах шаардлагагүй гэж үзлээ.

### **Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

1. Сангийн яамнаас баталсан орон тоог хэтрүүлсэн.

Шийдвэрлэсэн: Батлагдсан орон тоог барьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

2. Халаалтын зардлаас 950,0 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс, 320,0 мянган төгрөгийн засварын материал авч батлагдсан төсөвт зардлыг зориулалт бусаар зарцуулсан.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллан батлагдсан төсвийн зарлагыг эдийн засгийн ангилалын дагуу бүртгэж байх

### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Хэнтий аймгийн СХЗХ-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 18.8 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрсэн ба 2.2 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 15.5 сая төгрөг, төсвийн зарцуулалттай холбоотой 1.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгөв.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар зөвлөмж хүргүүлээгүй байна.

**Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:**  
**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хэнтий аймгийн СХЗХ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 6 хуудас, аудитын гэрчилгээ 2 хуудас, менежментийн захидал 5 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

**Аудитын тайланг**

Хянасан:

Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Ч.Эрдэнэбаатар

Д.Оюунтуяа

Х.Еркегүл

Огноо: 2018.02.14